

“Мастер Про-50” бүрэн биологийн цэвэрлэх байгууламжийг автомат удирдлага болон дизель генератор байрлуулах 12.0x2.4 м харьцаатай зөврийн дулаалгатай контейнерыг зурагт тусгасны дагуу байрлуулна.

Зайлшгүй тохиолдолд зураг төсөлд тусгасан “Мастер Про-50” бүрэн биологи цэвэрлэгээний цогц байгууламжийг ижил төстэй байгууламжаар солих шаардлага тулгарвал зураг төсөл зохиогчид мэдэгдэж бүрэн зөвшилцсөний дараа дараа угсралтын ажил эхлүүлнэ.

Барилга байгууламж, шугам хоолой угсралт, газар шорооны ажлыг гүйцэтгэх шаардлага:

- Угсралтын ажлыг хийж гүйцэтгэхэд хөндөгдөх зам, талбайг ажлын гүйцэтгэл дууссаны дараа буцааж булах хөрсийг сайтар нягтруулж, гудамж талбайд нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэх.
- Шугам хоолойг технологийн болон ажлын зураг төслийн дагуу хийх.
- Угсралтын ажлыг хийж гүйцэтгэхэд хөндөгдөх зам, талбайг ажлын гүйцэтгэл дууссаны дараа буцааж булах хөрсийг сайтар нягтруулж, гудамж талбайд нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэх.
- Шугам хоолойг технологийн болон ажлын зураг төслийн дагуу хийх.
- Барилга угсралтын ажил хийхэд тухайн нөхцөл байдалд тохирсон технологи, арга ажиллагааг сонгох, мөн барилга угсралтын ажил хийх цаг хугацааг зөв сонгох, хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааг чанд мөрдөж хийх хэрэгтэй.
- Полиуритан дулаалгаар дулаалан гадуур нь 2 үе ус чийг нэвтрүүлэхгүй хальсаар сайтар ороож хамгаална.
- Цахилгаан болон холбооны кабель шугам дагаж байгаа хэсэг холбогдох байгууллагын хяналтын инженерүүдийг байлцуулан газар шорооны ажлыг гараар гүйцэтгэнэ.
- Ажил хүлээлцэх: Системийн угсралтын ажлын бүрэн бүтэн байдлыг шалгаж, угсралтын ажлын ул болон далд ажлын акт тэмдэглэсэн байдлаар зураг зохиогч, захиалагч, хяналтын төлөөлүүдийг байлцуулан ажлыг хүлээлцэнэ.
- Угсралтын ажлыг гүйцэтгэхдээ “Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг сайтар мөрдөн ажиллах шаардлагатай.
- Ус хангамж, ариутгах татуургын системийн угаалга, шахалт, туршилт, тохируулгын ажлыг хийж гүйцэтгэсний дараа ашиглалтад өгнө.
- Ус хангамжийн шугамыг барьж байгуулахад дараах технологийг анхаарч үйл ажиллагаандаа баримтлахыг зөвлөж байна.
- Хөрсний ус гарсан тохиолдолд усыг хоолой угсрах түвшингээс доош 0.2-0.3м гүн шуудууны нэг талын ёроолыг дагуулан ухсан жижиг сувгаар урсган түүний төгсгөлд байгуулсан шүүр дүхий бага гүнтэй худагт цуглуулж, түүнээсээ насосоор шахаж ойр орчмын үерийн сувагт хаях аргаар зайлуулна. Ус цуглуулах шуудууны урт 50 м-ээс ихгүй байх ба шүүртэй худаг нь зөврийн байна.
- Буцаан булж дуй хөрсийг үелүүлэн тарааж бага оврын механикжсан гар удирдлагатай нягтруулагчаар нягтруулна.
- Төмөр бетоны гадна гадаргууг халуун битумээр 2 удаа будаж ус чийгийн тусгаарлалт хийнэ.
- Чугармал төмөр бетон худгийн гадна талыг Пенетрон Адмикс дүхий В20 ангийн шингэн шилтэй цементэн зуурмагаар гагнаж холбоосны дин битүү байдлыг байнга шалгаж байна.
- Барилгын ажил эхлэхийн өмнө трассын дагууд ул ба далд орших инженерийн шугам сүлжээний байршилыг дахин тодруулан холбогдох газруудаас зөвшөөрөл авах, улмаар барилгын ажлын үед харууцсан мэргэжилтнүүдийг байлгах.

- УХАТ-ын шугамыг байгуулахад ямар нэг байдлаар хөндөгдсөн инженерийн газар доорх ба дээрх шугам сүлжээ, тэдгээрийн барилга байгууламжийн талаар холбогдох байгууллагуудад актаар хүлээлгэн өгсөн байна.

- УХАТ-ын шугамын трасс ямар нэгэн сурталчилгааны самбарын, цахилгааны болон холбооны шугамын тулгуур, барилга байгууламжид нөлөөлөхүйц байвал гүйцэтгэгч захиалагч ба зохиогч байгууллагын төлөөлүүдийн хамт улаан шугам тавигдсаны дараа шийдвэрлэнэ. Ийм учраас улаан шугамыг маш сайн нарийвчлалтай газар дээр нь буулгуулж хэрэв асуудал байвал зохиогч, захиалагч байгууллагад хандах хэрэгтэй.

- Барилга угсралтыг технологийн дагуу хийхэд хүн хүч, мэргэжилтнээр сайн хангагдсан байхаас гадна тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах зориулалтын машин механизм, тоног төхөөрөмжийг хэрэглэнэ.









- УХАТ шугам хоолой, түүний барилга байгууламжийг барихдаа БНДЗ.05.04-90 нормыг мөрдлөг болгохоос гадна БНДЗ.01.01.-89, БНДЗ.01.03-88, БНДЗ.01.05-90 зэрэг батлагдсан норм дүрэм, нормативын шаардлагыг мөрдлөг болгоно.


ДОРНОГОВЬ АЙМГИЙН МАНДАХ СУМЫН ТӨВД ШИНЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ АРИУТГАХ ТАТУУРГЫН ШУГАМЫН БАЙГУУЛАЛТ М1:5000


Ахуйн бохир ус зайлуулах шугамын урт		
№	Нэр	урт/м
1	Гол коллектор	1487.0
2	Салбар шугам - 1	182.8
3	Салбар шугам - 1.1	90.9
4	Салбар шугам - 1.2	45.8
5	Салбар шугам - 2	232.8
6	Салбар шугам - 2.1	79.6
7	Салбар шугам - 3	382.0
8	Салбар шугам - 3.1	71.0
9	Салбар шугам - 3.2	24.2
10	Салбар шугам - 4	300.4
11	Салбар шугам - 5	426.5
нийт		3323.0



ТАНИЙХ ТЭМДЭГ

-  Ус хангамжийн эх үүсвэрийн шугам L=3260.4 м
-  Ус хангамжийн шугам L=1469.0 м
-  УС, дулаан дамжуулах шугам L=2827.6 м
-  Ариутгах татуургын шугам L=3298.0 м
-  Ундны усны эх үүсвэрийн гүний худаг 1 ш
-  Усан сан 50 м³ хос
-  Усан халаалтын зуух 1.1 мВт
-  Цэвэрлэх байгууламж 50 м³









“Хайдродизайн проект” ХХК
ХУД-ийн 15-р хороо, Малчин Ганди гудамж, Цэцэглэдэг хотон, 207-р байр
102 тоот
Утас: 99079769, 7279769
И-майл хаяг: info@hydro.mn

ДОРНОГОВЬ АЙМГИЙН МАНДАХ СУМЫН ТӨВИЙН ТӨЛӨРСӨН УС, ДУЛААН ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН ШУГАМ СҮЛЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ

Мандах сумын бохир ус зайлуулах шугамын байгуулалт

Инженер		П.Өлзийжаргал	Е.Г. Шифр НОР 03/2023	Масштаб: М1:5000	Огноо: 2023 он
Гүйцэтгэсэн		П.Өлзийжаргал	Т.Г. Шифр	Зургийн дугаар: ЦБ-1	Хуудас: -
Шалгасан		Б.Баасансүрэн			

ДОРНОГОВЬ АЙМГИЙН МАНДАХ СУМЫН ТӨВД ШИНЭЭР ТӨЛӨВЛӨЖ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ БАЙГУУЛАЛТ М1:200



50.0 м3 хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн холболтын хуудас

№	БУХ дугаар	Тайлбар
1	БУХ-1	Бохир усны энерги унтраах хуудас, Ф1500 мм, пк0+00
2	БУХ-2	Бохир усны үзлэгийн хуудас, Ф1000 мм, пк0+20
3	БУХ-3	Шүүх талбайн хувиарлах хуудас, Ф1000 мм, пк0+40
4	БУХ-4	Шүүх талбайн хувиарлах хуудас, Ф1000 мм, пк0+52
5	БУХ-5	Аваарын талбайд ахуйн бохир ус өгөх эргэлтийн хуудас, Ф1000 мм, пк0+10
6	БУХ-6	Аваарын талбайд ахуйн бохир ус өгөх эргэлтийн хуудас, Ф1000 мм, пк0+15
7	БУХ-7	Аваарын талбайн хувиарлах хуудас, Ф1000 мм, пк0+30
8	БУХ-8	Аваарын талбайн хувиарлах хуудас, Ф1000 мм, пк0+36
9	БУХ-9	Аваарын талбай юүлэх хуудас, Ф1000 мм, пк0+07
10	БУХ-10	Аваарын талбай юүлэх хуудас, Ф1000 мм, пк0+13
11	БУХ-11	Аваарын талбайн эргэлтийн хуудас, Ф1000 мм, пк0+20
12	БУХ-12	Аваарын талбайн эргэлтийн хуудас, Ф1000 мм, пк0+39

50.0 м3 хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн барилга байгууламж

№	БУХ дугаар	Тайлбар
1	№1	50 м3 хүчин чадалтай "Мастер Про-50" бүрэн биологи цэвэрлэгээний цогц байгууламж, Блок-1
2	№2	50 м3 хүчин чадалтай "Мастер Про-50" бүрэн биологи цэвэрлэгээний цогц байгууламж, Блок-2
3	№5	Цэвэрлэгдсэн ус шүүх талбай, I эгнээ S=120 м2 хос, II эгнээ S=56 м2 хос
4	№6	Аваарын талбай, S=9.0 м2 хос
5	№7	Лагийн талбай, S=1.0 м2 хос



ДОРНОГОВЬ АЙМГИЙН МАНДАХ СУМЫН ТӨВИЙН ТӨВЛӨРСӨН УС, ДУЛААН ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ				
Цэвэрлэх байгууламжийн инженерийн шугам сүлжээний байгуулалт				
Инженер	П.В.Лэйжаргал	Е.Г. Шифр	НОР 03/2023	Масштаб: М1:200
Гүйцэтгэсэн	П.В.Лэйжаргал	Т.Г. Шифр		Огноо: 2023 он
Шаллагсан	Б.Баасансүрэн	Зургийн дугаар: 6		Хувдас: -

